



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/55

Сүхбаатар сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.16, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.3, 13.2.10 тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих “Жишиг сум (Сэлэнгэ, Алтанбулаг сум)” байгуулах ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга

Я.Мөрөн

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд

Д.Октябрь

(Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Ч.Доржмягмар

(Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газрын)

Б.Мөнхбат

(Сэлэнгэ барилга захиалагч “ОНӨААТҮГ”-ын дарга)

Б.Ариунзаяа

(Алтанбулаг сумын Соёлын төвийн дарга)

Ж.Мөнхтуяа

(Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн
дарга


Х.Нэргүйбаатар

(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2.Тендер шалгаруулалтын ажиллагааг халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулан, холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, явц үр дүнгийн талаар

C:\users\albanbichig2021\zahiramj\A4.docx

420810141



танилцуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга, Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Я.Мөрөн)-д даалгасугай.

